



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

“Улаанбаатар марафон-2024”
Олон улсын гүйлтийн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/250 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар Марафон-2024” олон улсын гүйлтийн хаалтын арга хэмжээ 2024 оны 05 дугаар сарын 25-нд зохион байгуулсугай.


2. Хаалтын арга хэмжээний зардалд 4,455,000 (Дөрвөн сая дөрвөн зуун тавин таван мянга)-н төгрөгийг нэгдүгээр хавсралтаар баталж, нийтийн биеийн тамирын зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3. “Улаанбаатар марафон-2024” арга хэмжээний бэлтгэл ажлын штабыг байгуулж, штабын байршил болон ажиллах бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавралтаар баталсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамирын хэлтсийн дарга (С.Сувд)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Отгонсүрэн* Д.ОТГОНСҮРЭН





Баянзурх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны едрийн А/24 тушаалын нэгдүгээр хавсралт

ТӨСӨВ


2024 оны 04 дүгээр сарын 22

"Улаанбаатар марафон-2024"
Олон улсын гүйлтийн арга хэмжээ

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээний нэр болох газар	Өргөмжлөл, цом	Мөнгөн шагнал	Шүүгчийн хөлс, мөнгө	Бусад зардал	Нийт дүн
1	Улаанбаатар марафон-2024 Бөхийн өргөөний урд талбай, Сүхбаатарын талбай	2 төрлийн арга хэмжээний өргөмжлөл 10,000*6=60,000 15 байгууллагын батламж 15,000*15=225,000	2 төрлийн арга хэмжээний шагнал 500,000 Байгууллагуудын шагнал 1-р байр 200,000*5=1,000,000 2-р байр 150,000*5=750,000 3-р байр 100,000*5=500,000	Шүүгч 4*100,000=400,000 Хоол, усны зардал 14*30,000=420,000 Штабт ажиллах ажилтны цалин 2*100,000=200,000	Тээврийн зардал 100,000 Спорт үзүүлбэр 200,000 Байгууллагаар аялах хавтас 5*20,000=100,000	4,455,000

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын
хорооны даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны
өдрийн А/24 тушаалын хоёрдугаар хавсралт



1.Хаяг, байршил

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны байр буюу Баянзүрх дүүргийн 41 дүгээр хороо Отгонтэнгэр их сургуулийн баруун талд Ангорын байр 3 давхар 314 тоот өрөө.

2.Бүрэлдэхүүн

- Ерөнхий зохион байгуулалтыг Биеийн тамирын хэлтсийн дарга С.Сувд
- Бүртгэлийн дугаар олголтыг Биеийн тамирын арга зүйчийн асуудал хариуцсан мэргэжилтэн И.Бат-Эрдэнэ
- Техник, тоног төхөөрөмж, хэрэглэл материалын хангалтыг Нярав О.Түмэнжаргал